



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2025/155/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд
Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Мэдээлэл аудит ХХК-ийн
захирал: Д.Товуудорж
Утас: 99049511 Цахим хаяг: medeelelaudit@gmail.com

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025. 02. 24 № 01/102
танай -ны № -т

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН
ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВИЙН
ДАРГА М. МӨНГӨНЦЭЦЭГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал нийтээс хамарсан халдварт өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдлын хариу арга хэмжээний төсөл, Зонхилон тохиолдох нутагшмал Зоонозын халдваруудын байгалийн голомтын тархалтыг тандах, Зоонозын өвчний хүн амын дундах тархалтыг тогтоох тандалт судалгаа хийх эрсдлийн түвшинг тогтоох зэрэг зорилтын хүрээнд ажилласан байна. Мөн төсвийн санхүүжилтээр тайлант онд нийт 66,121,600 төгрөгийн 41 удаагийн төсөл арга хэмжээ зохион байгуулсан байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

02023484

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 100 хувийн хэрэгжилттэйгээр гүйцэтгэн, тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	242,364,898.16	432,639,208.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	0.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	0.00
34	УРЬДЧИЛГАА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	242,364,898.16	432,639,208.52
351	Түүхий эд материал	168,111,492.46	355,938,112.08
35130	Эм боох материал	168,111,492.46	355,938,112.08
354	Хангамжийн материал	74,253,405.70	76,701,096.44
35410	Бичиг хэргийн материал	1,468,149.98	1,825,349.98
35420	Аж ахуйн материал	12,923,734.99	11,582,984.99
35430	Сэлбэг хэрэгсэл	3,053,200.00	1,953,200.00
35440	Түлш, шатах тослох материал	175,000.00	
35470	Бусад хангамжийн материал	56,633,320.73	61,339,561.47
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,089,483,994.42	1,167,416,378.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,089,483,994.42	1,167,416,378.55
392	Биет хөрөнгө	895,462,519.40	981,432,378.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	616,609,237.11	616,609,237.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(173,155,490.34)	(208,811,764.26)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	224,600,000.00	379,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(56,749,999.77)	(103,409,721.96)
39205	Машин тоног төхөөрөмж	432,507,283.70	487,126,080.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	(161,733,230.75)	(202,899,281.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,996,550.01	46,786,550.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,611,830.56)	(33,468,721.07)
393	Биет бус хөрөнгө	194,021,475.02	185,983,999.88
39301	Програм хангамж	41,080,900.00	41,080,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,219,424.98)	(15,256,900.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	160,160,000.00	160,160,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,331,848,892.58	1,600,055,587.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,598,062.03	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,598,062.03	-
413	Өглөг	2,598,062.03	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,598,062.03	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,329,250,830.55	1,600,055,587.07
51	Засгийн газрын хувь оролцоо	1,329,250,830.55	1,600,055,587.07
511	Засгийн газрын оруулсан капитал	322,220,125.00	322,220,125.00
512	Хуримтлагдсан үр дүн	614,519,744.34	777,324,500.86
51210	Өмнөх үеийн үр дүн	614,519,744.34	614,519,744.34
51220	Тайлант үеийн үр дүн		162,804,756.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	392,510,961.21	500,510,961.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,331,848,892.58	1,600,055,587.07

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	981,608,561.15	1,202,500,292.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	348,162,261.15	310,009,033.26
120	Нийтлэг татварын бус орлого	320,245,594.47	310,009,033.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,854,500.00	7,125,450.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	293,265,103.10	100,388,996.42
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,125,991.37	202,494,586.84
122	Тусламжийн орлого	27,916,666.68	0.00
122001	Хандив тусламж /дотоод/	27,916,666.68	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	603,366,300.00	892,491,259.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	603,366,300.00	892,491,259.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	603,366,300.00	892,491,259.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,080,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,080,000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	704,693,454.69	1,039,695,535.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	704,693,454.69	1,039,695,535.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	694,016,083.24	955,291,204.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	427,449,183.11	615,232,736.00
210101	Үндсэн цалин	240,047,646.00	285,733,770.00
210102	Нэмэгдэл	114,605,905.11	228,854,358.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,530,000.00	49,063,227.09
210104	Урамшуулал	31,265,632.00	51,581,380.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	57,221,154.96	77,552,023.05
210201	Тэтгэврийн даатгал	34,163,136.23	53,753,516.38
210202	Тэтгэмжийн даатгал	7,483,717.23	5,246,899.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,373,166.50	7,008,406.75
210204	Ажилгүйдлийн даатгал	740,158.39	1,049,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,460,976.61	10,493,799.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,579,621.83	34,581,464.07
210301	Гэрэл, цахилгаан	8,261,114.75	8,924,763.27
210302	Түлш, халаалт	23,999,547.44	23,203,439.91
210303	Цэвэр, бохир ус	4,318,959.64	2,453,260.89
2104	Хангамж, бараа материалын зардал	40,528,511.08	33,822,642.58
210401	Бичиг хэрэг	2,073,890.00	2,529,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,026,500.00	23,735,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,855,099.08	1,538,242.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	465,000.00	280,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,415,022.00	5,739,000.00

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	
210408	Бараа материал акталсаны зардал	7,693,000.00	
2105	Норматив зардал	35,985,693.70	34,874,854.48
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,985,693.70	34,874,854.48
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,715,600.00	9,972,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,462,600.00	0.00
210604	Урсгал засвар	253,000.00	9,972,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,577,500.00	7,840,000.00
210702	Дотоод албан томилолт	7,577,500.00	7,840,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,899,509.00	6,987,072.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,605,500.00	5,556,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	563,940.00	590,820.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	151,962.00	138,952.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	54,000.00
210807	Газрын төлбөр	779,807.00	343,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	743,300.00	304,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,059,309.56	134,428,412.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	778,590.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,000.00	52,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,200,719.56	134,376,412.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,677,371.45	84,404,331.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,677,371.45	82,904,331.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,677,371.45	82,904,331.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	276,915,106.46	162,804,756.52
5	НИЙТ ҮР ДҮН	276,915,106.46	162,804,756.52

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	642,300,800.00	899,616,709.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,854,500.00	7,125,450.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,854,500.00	7,125,450.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,854,500.00	7,125,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	633,446,300.00	892,491,259.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	603,366,300.00	892,491,259.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	603,366,300.00	892,491,259.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,080,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,080,000.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	642,300,800.00	899,616,709.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	642,300,800.00	899,616,709.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	631,623,428.55	815,212,377.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	424,099,519.40	616,832,445.97
210101	Үндсэн цалин	231,359,318.56	285,733,770.00
210102	Нэмэгдэл	100,344,181.48	228,854,363.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,728,374.82	49,466,768.00
210104	Урамшуулал	50,667,644.54	52,777,544.00
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	56,675,054.34	78,550,375.11
210201	Тэтгэврийн даатгал	36,806,401.45	53,753,516.38
210202	Тэтгэмжийн даатгал	4,463,992.56	5,246,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,937,823.00	8,006,758.73
210204	Ажилгүйдлийн даатгал	751,640.01	1,049,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,715,197.32	10,493,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,579,621.83	34,581,464.07
210301	Гэрэл, цахилгаан	8,261,114.75	8,924,763.27
210302	Түлш, шатахуун	23,842,885.25	22,326,870.80
210303	Цэвэр, бохир ус	4,475,621.83	3,329,830.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,996,389.08	30,432,092.58
210401	Бичиг хэрэг	1,221,290.00	2,037,100.00
210402	Тээвэр, шатахуун	23,096,000.00	23,560,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,905,099.08	1,583,242.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	547,000.00	280,500.00

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,227,000.00	2,971,250.00
2105	Норматив зардал	26,902,734.90	26,340,128.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,530,234.90	23,028,128.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,372,500.00	3,312,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,943,100.00	12,791,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,950,000.00	3,919,800.00
210604	Урсгал засвар	9,993,100.00	8,872,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,577,500.00	7,840,000.00
210702	Дотоод албан томилолт	7,577,500.00	7,840,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,979,509.00	6,987,072.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,080,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,605,500.00	5,556,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	563,940.00	590,820.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	151,962.00	138,952.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	54,000.00
210807	Газрын төлбөр	779,807.00	343,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	743,300.00	304,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	870,000.00	857,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	870,000.00	857,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,677,371.45	84,404,331.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,677,371.45	82,904,331.27
213303	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,677,371.45	82,904,331.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	322,220,125.00	392,510,961.21	337,604,637.88	1,052,335,724.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-		-
Тайлант үеийн үр дүн			276,915,106.46	276,915,106.46
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	322,220,125.00	392,510,961.21	614,519,744.34	1,329,250,830.55
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		108,000,000.00		108,000,000.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
Тайлант үеийн үр дүн			162,804,756.52	162,804,756.52
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	322,220,125.00	500,510,961.21	777,324,500.86	1,600,055,587.07

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	940,483,600.00	812,212,377.73	128,271,222.27	86.4%
УРСГАЛ ЗАРДАЛ	940,483,600.00	812,212,377.73	128,271,222.27	86.4%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	885,382,900.00	810,712,377.73	74,670,522.27	91.6%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	664,879,800.00	616,832,445.97	48,047,354.03	92.8%
Үндсэн цалин	307,537,600.00	285,733,770.00	21,803,830.00	92.9%
Нэмэгдэл	264,386,000.00	228,854,363.97	35,531,636.03	86.6%
Унаа хоолны хөнгөлөлт	52,228,400.00	49,466,768.00	2,761,632.00	94.7%
Урамшуулал	40,727,800.00	52,777,544.00	-12,049,744.00	129.6%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	89,935,900.00	78,550,375.11	11,385,524.89	87.3%
Тэтгэврийн даатгал	63,524,500.00	53,753,516.38	9,770,983.62	84.6%
Тэтгэмжийн даатгал	5,246,900.00	5,246,900.00	0.00	100.0%
ҮОМШӨ-ний даатгал	9,621,300.00	8,006,758.73	1,614,541.27	83.2%
Ажилгүйдлийн даатгал	1,049,400.00	1,049,400.00	0.00	100.0%
Эрүүл мэндийн даатгал	10,493,800.00	10,493,800.00	0.00	100.0%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,164,900.00	34,581,464.07	13,583,435.93	71.8%
Гэрэл, цахилгаан	12,584,000.00	8,924,763.27	3,659,236.73	70.9%
Түлш, халаалт	31,882,500.00	22,326,870.80	9,555,629.20	70.0%
Цэвэр, бохир ус	3,698,400.00	3,329,830.00	368,570.00	90.0%
Хангамж, бараа материалын зардал	29,924,600.00	28,932,092.58	992,507.42	96.7%
Бичиг хэрэг	2,100,000.00	2,037,100.00	62,900.00	97.0%
Тээвэр, шатахуун	22,563,000.00	22,560,000.00	3,000.00	100.0%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	1,583,242.58	916,757.42	63.3%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	280,500.00	280,500.00	0.00	100.0%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,481,100.00	2,471,250.00	9,850.00	99.6%
Нормативт зардал	26,423,300.00	26,340,128.00	83,172.00	99.7%
Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	23,075,100.00	23,028,128.00	46,972.00	99.8%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,348,200.00	3,312,000.00	36,200.00	98.9%
Эд хогшил, урсгал засварын зардал	12,829,000.00	12,791,800.00	37,200.00	99.7%
Багаж, техник хэрэгсэл	3,924,000.00	3,919,800.00	4,200.00	99.9%
Урсгал засвар	8,905,000.00	8,872,000.00	33,000.00	99.6%

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Томилолт, зочны зардал	7,840,000.00	7,840,000.00	0.00	100.0%
Дотоод албан томилолт	7,840,000.00	7,840,000.00	0.00	100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тхур	4,523,700.00	3,987,072.00	536,628.00	88.1%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	2,556,000.00	2,556,000.00	0.00	100.0%
Даатгалын үйлчилгээ	739,700.00	590,820.00	148,880.00	79.9%
Тээврийн хэрэгслийн татвар	156,000.00	138,952.00	17,048.00	89.1%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,000.00	54,000.00	0.00	100.0%
Газрын төлбөр	343,300.00	343,300.00	0.00	100.0%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	674,700.00	304,000.00	370,700.00	45.1%
Бараа үйлчилгээний бусад зардал	861,700.00	857,000.00	4,700.00	99.5%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	861,700.00	857,000.00	4,700.00	99.5%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,100,700.00	1,500,000.00	53,600,700.00	2.7%
Бусад урсгал шилжүүлэг	55,100,700.00	1,500,000.00	53,600,700.00	2.7%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,590,000.00		53,590,000.00	0.0%
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,510,700.00	1,500,000.00	10,700.00	99.3%
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг			0.00	
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	940,483,600.00	895,116,709.00	45,366,891.00	95.2%
Улсын төсвөөс санхүүжих	938,483,600.00	892,491,259.00	45,992,341.00	95.1%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	2,625,450.00	-625,450.00	131.3%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	2,625,450.00	-625,450.00	131.3%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	19	19		
Үйлчлэх ажилтан	2	2		

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		4,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		4,500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,500,000.00
210402	Тээвэр шатахуун		1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,000,000.00
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		4,500,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,500,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		4,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,500,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв нь Нийслэлийн 9 дүүрэг, Төв аймгийн 27 сумын 1.5 сая орчим хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохион байгуулан бэлэн байдлыг хангах, халдвар хамгаалал, лабораторийн био аюулгүйн ажиллагааг сайжруулах, зоонозын халдварт өвчний талаарх мэдлэг хандлагыг дээшлүүлэх, судалгаанд тулгуурласан байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний судалгаа, шинжилгээний ажлыг оновчтой зохион байгуулах үйл ажиллагаа явуулдаг.

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв нь зоонозын халдвар, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шинжлэх ухааны нотолгоонд суурилан эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний цогц үйл ажиллагааг зохион байгуулах зорилт дэвшүүлэн тайлант онд эрүүл мэндийн яам, эрүүл мэндийг дэмжих сан контентаар дамжуулан нийгэмд тулгамдаж буй зоонозын шалтгаант халдварт өвчний чиглэлээр хүн амд боловсрол олгох, эрүүл мэндийн мэдээлэл сурталгаа хийн төслийн хүрээнд нэмэлт орлого бүрдүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 238 дугаар тогтоол "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ шинэчлэн тогтоох тухай";
- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дүгээр тогтоол "Журам батлах тухай" 7-р хавсралтад Засгийн газрын 2024 оны 12 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Нийгмийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналт аас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллага нь дотоод хяналтын хэлтэс, дотоод аудиторгүйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв байгууллагын удирдлагын 2020 оны А/25 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайланг 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бэлтгэсэн.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 268,206.69 мянган төгрөгөөр буюу 17.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	242,364.9	432,639.2	190,274.3
Үндсэн хөрөнгө	1,089,484.0	1,167,416.4	77,932.4
Нийт хөрөнгө	1,331,848.9	1,600,055.6	268,206.7
Өр төлбөр	2,598.1	-	(2,598.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,329,250.8	1,600,055.6	270,804.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,331,848.9	1,600,055.6	268,206.7

Бараа материал нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 64,535.5 мянган төгрөг, хандиваар 202,494.6 мянган төгрөг, нийт 267,030.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 76,755.8 мянган төгрөгөөр хасагдаж, 432,639.2 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан нь өмнөх оны үлдэгдэлээс 56.0 хувиар өссөн байна.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/169 дугаар “Хувийн хамгаалах хэрэгсэл хуваарилах тухай” тушаалаар хамгаалах өмсгөл 142,742.5 мянган төгрөг, нүүрний хаалт 7,826.7 мянган төгрөг, нэг удаагийн маск 12,925.0 мянган төгрөг, нэг удаагийн халад 17,160.0 мянган төгрөг, аюултай хог хаягдлын уут 6,973.2 мянган төгрөг, нийт 187,627.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан нь бараа материалын үлдэгдлийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө 77,932.4 мянган төгрөгөөр өссөн нь 3,919.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/681 дугаар захирамж, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/46 дугаар тушаалаар Камаз маркийн 5795УБЛ улсын дугаартай автомашиныг балансаас балансад шилжүүлэхдээ дахин үнэлгээ хийлгэж 108,000.0 мянган төгрөг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/608 дугаар захирамж, Нийслэлийн өмчийн

харилцааны газрын даргын 2024 оны 2/1001 дугаар тушаалаар Нийслэлийн Төр захиргааны авто баазаас нийт 35,000.0 мянган төгрөгийн Хьюндай Старекс маркийн 8166УНУ улсын дугаартай, 11,900.0 мянган төгрөгийн Тоёота приус маркийн 4583 УНУ улсын дугаартай автомашиныг балансаас балансад шилжүүлж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 50,659.2 мянган төгрөгийн нян судлалын лабораторийн 15 ширхэг тоног төхөөрөмжийг Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/26 дугаар тушаалаар 2,829.7 мянган төгрөгийн лед дэлгэц зэрэг нийт 208,968.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, тайлант онд 134,376.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой тус тус холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,265,949.5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2,000.0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,267,949.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 540,231.3 мянган төгрөгөөр бууруулж, 727,718.2 мянган төгрөгөөр баталсан нь төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор бууруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотойгоор батлагдсан төсвийг 212,765.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 938,463.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 892,491.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 2,625.4 мянган төгрөгийг бүрдүүлж, 812,212.4 мянган төгрөгийг зарцуулж, 82,904.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 895,116.7 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь гүйцэтгэлээр төсвийг 45,366.9 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	70101-Нийгмийн эрүүл мэнд	940,483.6	895,116.7	45,366.9	95.2
2	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	940,483.6	895,116.7	45,366.9	95.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр үндсэн үйл ажиллагааны хүрээнд 4,500.0 мянган төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 1,500.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжинд 3,000.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар үндсэн хөрөнгийг өөрийн нэр дээр шилжүүлэх, шатахууныг батлагдсан нормоор зарцуулах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мэдээлэл аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Туяа, аудитор Ц.Отгонжаргал, аудитор Н.Пүрэвсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа, компанийн захирал Д.Товуудорж нар анхан шатны чанарын хяналтыг, НТАГ-ын Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Д.Отгонбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр, газрын дэд дарга Ч. Болд, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нийслэл дэх Төрийн газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 704,693.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,570.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага төрийн нарийн бичгийн дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахгүй, ажилтан албан тушаалтнууд гадаад, дотоод албан томилолтоор ажиллаагүй зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих орлогын 911,698.16 мянган төгрөгийн 16 мэдээ, нийт мэдээлэлбэл зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон 98.0 хувийн биелэлттэй байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн дагуу иж бүрэн цаглабар хугацаанд оруулж хэвших зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулаагүй, мэдээллээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулж, мэдээллийг бүрэн цаглабарт хугацаанд оруулж хэвших зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

2. Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба

түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-д "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-д "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна." гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр бараа материал худалдан авахдаа ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авч байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд цахим и-баримтын бүрдэл хангалтгүй, үндсэн хөрөнгийн бүртгэл дутуу, шилэн дансны мэдээлэл хоцроосон, шатахууны зарцуулалт илүү тайлагнасан, бараа материалын үлдэгдэл их зэрэг нийт 3,905.0 мянган төгрөгийн 5 зөрчлийг илрүүлж, зөвлөмж өгснийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 2,387.0 мянган төгрөгийн цахим и-баримтын бүрдэлийг хангаж, шилэн дансны хоцроосон мэдээлэлд зөвлөмж өгч, 87.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 247.4 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг биелүүлээгүй ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	247.4	1	247.4	100.0
Зөвлөмж	2	-	2	-	0
Нийт дүн	3	247.4	3	247.4	50.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр үнэ төлбөргүй нийлүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүйг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 83,006.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Батлагдсан төсвийг төсвийн гүйцэтгэлийн тайланд 102.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг;
- Мөнгөн гүйлгээний тайлангаас төвлөрүүлэх шилжүүлгийн 82,904.3 мянган төгрөгийн зардлыг тохируулга хийж, төсвийн гүйцэтгэлийг цэвэр дүнгээр тайлагнаагүй нь санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 87.2 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс, 87.2 мянган төгрөгийн төлбөрийн 1 акт тогтоож, 1 албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд 87.2 мянган төгрөгийн шатахууныг батлагдсан нормоос илүү зарцуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална:", 5.1.3-д. "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д. "үнэн зөв байх" заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм", санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан нормоос илүү зарцуулсан шатахууныг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх тухай" А/506 дугаар тушаалаар хүлээн авсан 5876 УНЛ дугаартай тээврийн хэрэгслийн эзэмшлийн нэр солиулаагүй үндсэн хөрөнгөд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Тээврийн хэрэгслийг өөрийн өмчлөлд шилжүүлэх албан шаардлага өгөв.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусУад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулс ан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдсан төсөв, төсвийн төлөвлөгөө зөрүүтэй	1	102.0			1	102.0	1	102.0				
төсвийн гүйцэтгэлийг цэвэр дүнгээр тайлагнаагүй	1	82,904.3			1	82,904.3	1	82,904.3				
Дүн	2	83,006.3			2	83,006.3	2	83,006.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Шатахууны норм хэтрүүлсэн	1	87.2	1	87.2								
Шилжиж ирсэн хөрөнгийн нэр шилжүүлээгүй бүртгэлд тусгасан	1	-			1	-						
Дүн	2	87.2	1	87.2	1	-						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих мэдээллээс 2 мэдээлэл хугацаа хоцроосон.	1	-					1	-
Төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулаагүй, мэдээлээгүй байна.	1						1	-
Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна	1	20,801.6					1	20,801.6
Дүн	3	20,801.6					-	20,801.6

Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

ХЯНАСАН:

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТОВУУДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Н. ПҮРЭВСҮРЭН



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 8/13710508

Улаанбаатар хот

НТАГ-2025/155/НА-СТА-Тшз

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 87,152.00 (наян долоон мянга нэг зуун тавин хоёр) төгрөгийн шатахуун илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцээгүй, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3. "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6 "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв шатахуун илүү зарцуулсан зөрчлийн 87,152.00 (наян долоон мянга нэг зуун тавин хоёр) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ хүү орлогын 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар¹-т ирүүлэхийг Нийслэлийн Зоонозын өвчин судлалыг төвийн дарга М. Мөнгөнцэцэг, нягтлан бодогч Р. Саранцэцэг нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН¹:

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Д.ТОВУУДОРЖ

ХЯНАСАН:

САНХҮҮ НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 33/13716508

Улаанбаатар хот

НТАС - 2025/155/НА-СТА-Тулз

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Тээврийн хэрэгсэл балансаас балансад шилжүүлэх тухай" А/506 дугаар тушаалаар хүлээн авсан 5876 УНЛ улсын дугаартай тээврийн хэрэгслийн эзэмшлийн нэр солиулаагүй үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Тээврийн хэрэгслийг өөрийн өмчлөлд шилжүүлж, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Зоонозын өвчин судлалыг төвийн дарга М. Мөнгөнцэцэг, нягтлан бодогч Р. Саранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК ЗАХИРАЛ

Д. ТОВУУДОРЖ

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР

